



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА Б.БАЛГАНСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.27 № 1/13 ЧАГ-САГ/2014/98/СТГА-ТШЗ

Албан томилолтын зардал
нөхөн төлүүлэх тухай

Үндэсний аудитын газраас баталсан хуваарийн дагуу Холбооны Зохицуулах Хорооны 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос Арвайхээр хотод зохион байгуулсан төвийн бүсийн семинарт хорооноос 24 хүн албан томилолтоор 39 хүн/хоног Арвайхээр хотод ажиллах албан томилолт, байр, хоолны зардал Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалаар батлагдсан нормоор аймгийн төвд хоногт 29,000.0 төгрөгөөр тооцоход 1,131,000.0 төгрөг олгох байтал 2,480,000.0 төгрөг зарцуулсан нь албан томилолтын төсвийн нормыг 1,349,000.0 төгрөгөөр хэтрүүлсэн. (Жич: семинарын арга хэмжээний төсвөөр 7,388,700.0 төгрөгийн хоол хүлээн авалт хийснийг тооцоогүй.)

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны Б.Балгансүрэн, Ч.Оюунгэрэл, З.Амгалан нар Лондон хотноо байрны зардал 262.8 ам доллар, 290.0 ам долларын ерөөнд байрласнаас гадаад томилолтын байрны зардлыг тогтоосон Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалын нормоос 1,670.4 ам доллар буюу 2,883,227 төгрөг 32 мөнгөөр хэтрүүлж, бүгд 4,232,227 төгрөг 32 мөнгөний томилолтын зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.

Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 -д "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах, акт тавих, албан шаардлага өгөх, ..." гэсэн заалт, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2.1.1-ийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- 1) Албан томилолтын төсвийн нормыг хэтрүүлэн хэрэглэсэн 4,232,227 төгрөг 32 мөнгийг хариуцагчдаар төлүүлж Үндэсний Аудитын Газрын Төрийн Сангийн 900000601 тоот дансанд 2014 оны 4 дүгээр сарын 30-ны дотор төвлөрүүлэх,
- 2) Тогтоосон хугацаанд төлбөрийг барагдуулж биелэлтийг 2014 оны 5 дугаар сарын 20-ны дотор Үндэний Аудитын Газарт ирүүлэхийг Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны дарга Б.Балгансүрэн, ерөнхий нягтлан бодогч Д.Насанжаргал нарт хариуцуулав.

Тогтоосон:

Үндэсний Аудитын Газрын
Аудитор *Ж.Болормаа* Ж.Болормаа

УХА0122

АКТЫГ

Зөвшөөрсөн:

ХХЗХ-ны дарга *Б.Балгансүрэн*
Б.Балгансүрэн
Ерөнхий нягтлан бодогч
Д.Насанжаргал

Албан томилолтын тооцоо

Үзүүлэлт	Байгууллагаас олгосон				Аудитын тооцоогоор				Зөрүү
	Хүний тоо	Хоног	Хоногийн зардал	Дүн	Хүний тоо	Хоног	Хоногийн зардал	Дүн	
Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос Арвайхээр хотод зохион байгуулсан сургалт семинарын зардлын тооцоо									
Зочид буудал	3		120,000	360,000	39	1	29,000	1,131,000	1,349,000
Хагас люкс	9		80,000	720,000					
Энгийн өрөө	28		50,000	1,400,000					
Дүн				2,480,000				1,131,000	1,349,000
Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны даргын 2013 оны 10 дугаар сарын 04-ны 233 тоот тушаалаар Б.Балгансүрэн, Ч.Оюунгэрэл, З.Амгалан нарын Лондонгийн томилолт									
Лондон зочид буудал	2	9	262,8 \$	4730.4 \$	2	9	200 \$	3600 \$	1130.4 \$
Лондон буудал	1	6	290 \$	1740 \$	1	6	200 \$	1200 \$	540 \$
Дүн (ам доллар)				6470.4 \$				4800 \$	1670.4 \$
Дүн (MNT)				11,168,366				8,285,139	2,883,227
Нийт дүн (MNT)									4,232,227

Тооцоог үйлдсэн:

Аудитор



Д.Гэндэнпэлжээ

Тооцоог хянасан:

АЧХМ



Б.Мөнхцацрал